Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 сарын 24-ны өдрийн
А/92 тоот тушаалын Хоёрдугаар хавсралт Маягт-9

MONGOLIA NETCOM

ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

БАТЛАВ:
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ГАЗРЫН ДАРГА
.....Ш.АРДАХ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар А-А2025/25

Баян-Өлгий аймаг 2025 оны 05 сарын 27 өдөр

Захиалагч байгууллага: Толбо сумын ЕБ-ын Сургууль

Хэрэглэгчийн нэр: Б.Даулет

Харилцах утас: 94486644

Байршил: Баян-Өлгий аймаг Толбо сум 5-р баг

Сувагчлалаар татах шилэн кабелийн хэрэгцээ:

д/д	Кабель шугамын тасаг	Чиглэлийн нэр:	Шилэн кабелийн урт (м)	Агаарын багана тоо (м)
1	Баян-Өлгий аймгийн МХС ХХК-ийн КШ-ын тасаг.	МХС ХХК-ийн Толбо сумын холбооны салбарын байраас шинээр баригдах Толбо сумын ЕБ-ын Сургуулийн барилга хүртэл шинээр 4ш бетон хөлтэй агаарын багана босгож 386м агаарын шилэн кабель татаж техникийн өрөөнд оруулан төгсгөлийн төхөөрөмж болох FDF-д холбож өгнө.	386	4

1. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгогдсон харилцаа холбооны үндсэн сүлжээ байгуулах эрхийнхээ дагуу техникийн нөхцлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгоно. Техникийн нөхцөлгүйгээр холбооны худаг сувагчлал байгуулах, кабель татах, шилжүүлэх тохиолдолд уг барилга обьектыг техникийн комисс болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.
2. **Техникийн үндсэн нөхцөл:**
   - 2.1 Угсралт суурилуулалтын ажлыг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэнэ.
   - 2.2 Худаг сувагчлалаар шинээр шилэн кабель суурилуулахдаа Монгол Улсын MNS 5207:2011, MNS 5278:2012, MNS 5317:2011 стандартуудыг мөрдөнө.
   - 2.3 Угсралтын ажил эхлэхийн өмнө тус газрын харъяалагдах нэгжид мэдэгдэн ажил эхлэх зөвшөөрөл авна.
   - 2.4 Техникийн нөхцлийн дагуу гүйцэтгэсэн ажлыг техникийн актаар хүлээлгэн өгөөгүй тохиолдолд түүнд гарах аливаа эрсдэл, гэмтэл саатлын хариуцлагыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК хариуцахгүй болно.
   - 2.5 Техникийн нөхцлийн дагуу худаг сувагчлалын түрээсийн гэрээ байгуулна.

3. **Угсралтын ажлын үед тавигдах шаардлага:**
   3.1 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтран хяналт тавьж, угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх.
   3.2 Шилэн кабелийг худагт нөөц үлдээхгүй татах бөгөөд зөвхөн төгсгөлийн төхөөрөмж байрлуулах хэсэгт нөөц авахыг зөвшөөрнө.
   3.3 Шинээр татсан кабельд биркийг /хаягжилт/ худаг бүрт болон төгсгөлийн төхөөрөмжид бүрэн хийсэн байх ба худагт кабелийн залгаа хийх тохиолдолд муфтыг худгийн хананд тусгай тавиур хийж байрлуулсан байх.
   3.4 Кабелийг техникийн нөхцөлд заасан трассын дагуу татаагүй тохиолдолд ашиглалтын явцад гарах эрсдэлийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК хариуцахгүй болно.

4. **Угсралтын ажил дуусаны дараа тухайн ажлыг AutoCAD-ын гүйцэтгэлийн зураг хийлгэж, тухайн ашиглалт хариуцсан газарт техникийн актаар хүлээлгэн өгнө.**

5. **Техникийн нөхцлийг ТОЛБО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2025 оны 05 сарын 22-ний өдрийн 61 тоот хүсэлтийг үндэслэн олгов.**

6. **Энэхүү техникийн нөхцөл нь батлагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна. Техникийн нөхцлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгалт хийлгэх хүсэлт хүлээн авч, сунгах боломжтой.**

Хянасан: ..... К.ЕСИМ
/ Ерөнхий инженер /

Боловсруулсан: ..... М.ЖЕНИС
/ КШ-ын инженер /

ТОЛБО СУМЫН 640 ХҮҮХДИЙН СУРГУУЛИЙН БАРИЛГА ХҮРТЭЛ ТАТАГДАХ ШИЛЭН КАБЕЛИЙН ЗУРАГ



ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР: К. ЕСИМ

ЗУРСАН:

КАБЕЛЬ ШУГАМЫН ИНЖЕНЕР: М. ЖЕНИС

БАТЛАВ:ЦШСГ-ЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР ..... Х.ДАРМЕН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ ТУХАЙ

ӨЛГИЙ СУМ №25/100 2025.05.27

Техникийн нөхцөл хүссэн иргэний газрын байршил: Толбо сумын 5-р баг байрлалтай нэгж талбарын 8308000003 дугаар бүхий 34251м.кв талбайтай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй Толбо сумын ерөнхий боловсрлын сургуулийн шинээр баригдах сургуулийн байрыг 380В-ын ЦЭХ-ээр дараах байдлаар хангана.

1. АТП-6 дэд станцад шаардлага хангасан щит байрлуулж ААБГ-3х70+1х50 маркийн хос кабелиар татаж тэжээнэ.
2. Уг щитэнд 400А-ийн рубильник, 5А-ийн DDZY88 /мэйжүрмент/ маркийн сим карттай ухаалаг тоолуур, 100/5А-ийн гүйдлийн трансформатор, 200А-ийн автомат суурилуулж тус тоолуур нь Цахилгаан Шугам Сүлжээний Газрын (ЦШСГ) ухаалаг тоолуурын системд нийцэж ажилладаг, мэдээлэл цуглуулах GSM сүлжээгээр мэдээлэл дамжуулах сим картны оролттой тоолуур суурилуулах.
3. Уг сургуулийн байрны барилгын газардуулгын байгууламжыг норм дүрмийн дагуу угсарч шаардлагатай туршилт хэмжилтийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, ил далд ажлын акт үйлдэж зургаар баталгаажуулах.
4. Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх "Тусгай зөвшөөрөл" бүхий мэргэжлийн байгууллага болон (компани)-р гүйцэтгүүлэх.
5. Хэргэлэгчийн өөрийн өгсөн хүчин чадалд горим тооцоо хийж техникийн нөхцөл олгож байгаа ба нэмэлтээр цахилгаан тоноглол ашиглах хүчин чадал нэмэгдүүлэх өргөтгөх тохиолдолд зайлшгүй ЦШСГ-т мэдэгдэж нэмэлт горим тооцооны судалгаа хийлгэх.
6. Тухайн 380В-ын холболт нь Аюулгүй Ажиллгааны Дүрэм (ААД) Техникийн Ашиглалтын Дүрэм (ТАД) дагуу угсарагдсан байх.
7. Аймгийн ГХБХБГ-ын мэдээллийн санд бүртгүүлж тодорхойлолттой байх.
8. Шинээр холболт хийх журмын дагуу холбогдсон байх ба борлуулалтын албанд гэрээ хийх. Гэрээнд тоолуур, гүйдлийн трансформаторын гэрчилгээ, газардуулгын байгууламжийн акт зэрэг баримт бичгүүдийг хавсаргаж өгөх.
9. Техникийн нөхцөл олгосны суурь хураамж болох 165000 төгрөг төлсөн байх.
10. Уг техникийн нөхцөл хоёр жилийн дотор хүчинтэй.

ТЕХНИКИЙН КОМИССЫН ГИШҮҮД:

ТЕХНИКИЙН АЛБАНЫ ДАРГА	А.ЖАЛГАС
АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР	А.АБЛАЙХАН
БОРЛУУЛАЛТЫН ИНЖЕНЕР	Е.НУРЛАН
ГОРИМ ТООЦООНЫ ИНЖЕНЕР	Б.МЕЙРАМ
БОЛОВСРУУЛСАН:РХТТКШ-ЫН ИНЖЕНЕР	Х.ЖАРДЕМ